



ЖОРЛОНГОО ӨӨРЧИЛЬЕ

ТА ХАШААНДАА ЖОРЛОНГОО БАРИХ ГЭЖ БАЙНА УУ?



ТАНЫ өнөөдрийн нэг зөв үйлдэл маргаашийн ногоон ирээдүйд үнэтэй хувь нэмэр оруулах болно.

- + Эрүүл, эко
- + Стандартын
- + Хөрсний бохирдолгүй
ЖОРЛОН барьцгаая.

ХӨРСИЙГ БОХИРДУУЛАГЧ НҮХЭН ЖОРЛОН



Өнөөдөр та бидний өмнө ХХ зууны модон жорлонг нэн даруй халж, ариун цэврийн байгууламжийн дэд бүтцийг ХХI зууны хөгжил дэвшилд нийцүүлэн цоо шинээр төлөвлөх шаардлага тулгарч байна.

Засгийн газрын болон Говьсүмбэр аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд “Гэр хороолол болон аялал жуулчлалын бүсэд “Эко жорлон” арга хэмжээ хэрэгжүүлж, хөрсний бохирдлыг бууруулна” гэсэн зорилгод тусгагдсан.

Нүхэн жорлонгийн буруу хэрэглээний хор уршиг

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын тооцоогоор нэг хүн өдөрт дунджаар 200 грамм өтгөн, 1.5 литр шингэн ялгадас ялгаруулдаг байна. Хүнээс гадагшлах шээсний 91-96% нь ус, үлдсэн хэсгийг эрдэс давс, органик нэгдлүүд эзэлдэг. Харин өтгөний 75%-г ус, үлдсэн 25%-г уураг, бактери, задраагүй өөх тос, нүүрс ус гэсэн хэсгүүд бүрдүүлдэг.

Ил задгай жорлонгийн хаягдлаас ялгардаг шивтрийн хий нь хорт хийний төрөлд хамаарагддаг бөгөөд хорын зэрэглэлээрээ дөрөвдүгээрт багтдаг байна.

Шивтрийн хий ихэссэнээр хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхээс гадна эхийн урагт нөлөөлж, гажиг, согогтой хүүхэд төрөх, цаашлаад хүнийг үргүйдүүлэх хор уршигтай.

Гадаргын болон газрын доорх усыг бохирдуулдаг. Халдварт өвчнийг үүсгэдэг. Үүнд: Цусан суулга, халдварт шар, балнад, урвах тахал, малаас хүнд дамжин халддаг боом, бруцеллөз, мэрэгч амьтдаас хүнд халддаг тарваган тахал, галзуу, шимэгч хорхойн халдварууд гэгддэг хялгасан хорхой, цагаан хорхой, өргөн туузан хорхой, үхрийн болон гахайн туузан хорхой, сүрьеэ, амьсгалын замын өвчин зэрэг болно.

БИДЭНД БОЛОМЖ БАЙНА.

НОГООН ЗЭЭЛ: Агаарын бохирдлыг бууруулахад чиглэгдсэн эрчим хүчний тоног төхөөрөмж, дулаалгын материал, усны хэрэглээ, бохирын байгууламжийг шийдвэрлэх зориулалт бүхий бүтээгдэхүүн, үйлчилгээ худалдан авахад зориулсан зээл.

/ХААН, ХАС, ТӨРИЙН банкууд/



Хүн амын эрүүл мэндэд аюул учруулж буй
"ЧИМЭЭГҮЙ ТАХАЛ" бол хөрсний бохирдол юм.

ЭРҮҮЛ ХӨРС
ЭРҮҮЛ АМЬДРАЛ





Та үүнийг мэдэх үү?

ДЭЛХИЙН
ЖОРЛОНГИЙН
ӨДӨР ХЭЗЭЭ
БОЛДОГ ВЭ?

Жил бүрийн **11-р сарын 19**-ний өдрийг “Дэлхийн жорлонгийн өдөр” болгон тэмдэглэж, орон бүрийн нөхцөл, шаардлагад тохирсон жорлонгийн технологийг шинээр зохиох, бохир зайлуулах үр дүнтэй аргыг сурталчлах, ялгадсын аюулыг нийтэд ойлгуулах гэх мэт олон ажлыг зохион байгуулдаг.

**World
Toilet
Day**



Та үүнийг мэдэх үү?

ХҮН ӨДӨРТ
ХЭДЭН УДАА
ХҮНДЭЭР БИЕ
ЗАСДАГ ВЭ?




Эрүүл хүн идсэн хоолныхоо шингээгүй үлдэгдэл, бас бус хаягдлаасаа тогтмол салж, өдөрт **3-4 удаа** хүндээр бие засч, гэдсээ тухай бүрт цэвэрлэх биологийн чадавхитай.

ХҮНИЙ ЭРҮҮЛ МЭНДЭД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨ

НҮХЭН ЖОРЛОН НЬ ТУХАЙН ОРЧНЫ АГААР, ХӨРСНИЙ
УСЫГ БОХИРДУУЛААД ЗОГСОХГҮЙ НИЙТИЙГ ХАМАРСАН
ХАЛДВАРТ ӨВЧЛӨЛИЙН ЭХ ҮҮСВЭР БОЛДОГ.

Зураг 2: Ялгадаснаас үүдсэн хөрсний бохирдлын хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөө



НҮХЭН ЖОРЛОН

ГЭР, АМИНЫ ОРОН СУУЦ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРААС

15м-ийн зайд

ГОЛЫН ЭРГЭЭС

200–250 м-ийн зайд


УС ТҮГЭЭХ ЦЭГ, ГҮНИЙ ХУДГААС

20м-ийн зайд

БАЙРЛАХ ЁСТОЙ.

Т.Г.Орчин 19
ДЭЛХИЙН
ОО-ЫН
ӨДӨР

Нүхэн жорлон, угаадасны нүхийг шинэчлэн, шинээр барихдаа иргэн Та төвлөрсөн шугамд холбогдоогүй айл, өрх, албан байгууллагын хэрэгцээнд зориулсан “Нүхэн жорлон, угаасдасны нүх: Техникийн шаардлага MNS5924:2015 стандартыг мөрдлөгө болгоно. Энэхүү стандартаар дараах 3 төрлийн нүхэн жорлонг гэр хороололд хэрэглэхээр тусгасан байдаг.



Хөрс бохирдуулахгүй, эко, стандартын ариун цэврийн байгууламжийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн мэдээлэл

№	Нэрс	Чиглэл, бүтээгдэхүүн	Холбоо барих утас
1	Илчилт сансар ХХК	✿ Говьсүмбэр –Бетон кольцо	99542115
2	Ус-Ду ОНӨҮГ	✿ Үйлчилгээ	70543270, 99908737
3	Пластик центр ХХК	✿ Хаягдал гялгар уут дахин боловсруулж, бохирын хуванцар кольцо, 100 % битүүмжит нүхэн жорлонгийн доторлогоо, траншейны таг ✿ Нүхэн жорлонгийн багц үйлчилгээ	70004308
4	Эколос ХХК	✿ ТОПАС төхөөрөмж Ахуйн бохир ус цэвэрлэх бичил төхөөрөмж	90938888
5	Урта камел транс ХХК	✿ Биолос-бохирын төгс шийдэл /үнэргүй, хөлдөхгүй, соруулахгүй бохир цэвэрлэх станц/	93336668, 99757006
6	Юнилос	✿ Бохирын төгс шийдэл-Септик технологи, цэвэршүүлэх станц	90936000, 90946000
7	Vulcan Mongolia Ricing Development Mongolia Албан ёсны дистрибьютер	✿ Герман технологи ✿ Шугам хоолойн өнгөр, зэв арилгах төхөөрөмж-давсгүй, соронзгүй, хиймийн бодисгүй, засвар үйлчилгээгүй, Септик төхөөрөмж	72272828
8	Аривжих уялга ХХК	✿ Хуурай экологийн нийтийн биореактортой нийтийн бие засах газар ✿ Экологийн био идэвхит задралын хуурай жорлон ✿ Эргэлтийн ситем бүхий эко жорлон	72720909, 94119668
9	Жондоо Гарден ХХК	✿ JONDOO хөрсний бохирдлын эсрэг соруулдаг эко жорлон	80802399, 99189603
10	Ультрасоник ХХК	✿ Ахуйн бохир ус цэвэрлэх WSB технологи /цэвэрлэх байгууламж/	
11	Тансаг элемент ХХК	✿ Айл, өрхийн Цэвэр бохирын систем	86201177
12	Эко байгууламж од ххк	✿ Эко жорлонгоо цогцоор нь хийх үйлчилгээ	88117925, 99993778
13	Дөрвөн ат ХХК	✿ Соруулдаг ЭКО ЖОРЛОН	89998089 89891777
14	Танан шанага ХХК	✿ Цэвэр, бохир, сан, халаалтыг шийдэж өгч байна. 5.2тонн сефтик танк шингээгчийн хамт	80193464
15	Тэрх хийц ХХК	✿ төмөр бетон худгийн ховилтой дугуйвч /КС-10, КС-15/ , ховилгүй дугуйвч /КС-7, КС-20/ болон тэдгээрт тохирсон төмөр бетон нүхтэй , нүхгүй хучилт /таг/, гадна нойлын зориулалттай хавтан зэрэг бүтээгдэхүүн	86047888, 90904497

Ерөнхий шаардлага

Жорлонгийн шалыг ачаалал даах материалаар, бүхээгийг ялаа шавьж орохооргүй битүүмжлэл сайтай хийнэ.

+ Эрүүл ахуйн шаардлага


Ариун цэврийн цаас, хог хаягдлыг тагтай хогийн саванд хийнэ.

📍 Байршил

Жорлонг гэр, амины орон сууцны гадна эсвэл залгаа байхаар төлөвлөнө.

Хэрэглээ үйлчилгээ

- Бүхээгт үртэс, хар шороо зэрэг органик материалаар дүүргэсэн сав байрлуулна. Бие зассаны дараа ялгадсыг тухайн органик материалаар далдалж хучина.
- Жорлонгийн шалыг усаар тогтмол угааж, цэвэрлэнэ.
- Өтгөн хураах саванд угаадас, хог хаягдал, халдваргүйжүүлэгч бодис хийхийг хориглоно.
- Агааржуулалтын хоолойг хар өнгөөр будах ба энэ нь ялгадас хатах явцыг дэмжинэ.



🔧 ШИНЭЧЛЭХ ШИЙДЭЛ 2: БАГА УСААР ЗАЙЛУУЛДАГ ЖОРЛОН

Ерөнхий шаардлага

Жорлонг дүүрсэн үед бохирыг соруулан зохих журмын дагуу зайлуулна.

+ Эрүүл ахуйн шаардлага


Цахилгаанд холбох боломжтой бол зохиомол гэрэлтүүлэг хийнэ.

📍 Байршил

Жорлонг амины орон сууцны дотор эсвэл гадна байхаар төлөвлөнө.

Хэрэглээ, үйлчилгээ

- Ялгадсыг зайлуулахдаа зөөврийн устай тохиолдолд нэг удаад 2-3 литрээс багагүй, ус нөөцлөх савтай тохиолдолд 4 литрээс ихгүй хэмжээний ус хэрэглэнэ.
- Шалыг бага зэрэг налуу хийх ба энэ нь усны урсацыг сайжруулдаг.
- Бүхээг нь нүхний дээр байрлах хувилбарыг дулааны улиралд хэрэглэнэ.
- Бүхээг нь нүхний хажууд байрлах хувилбарыг хүйтний улиралд хэрэглэх тохиолдолд "S хэлбэрийн хаялга" болон ялгадас зайлуулах хоолойг дулаална.



БАГА УСААР ЗАЙЛУУЛДАГ ЖОРЛОН

ҮҮХЭН ЖОРЛОНГИЙН ТӨРӨЛ-2

ШИНЭЧЛЭХ ШИЙДЭЛ 3: ХУУРАЙШУУЛАХ ЖОРЛОН

ХУУРАЙШУУЛАХ ЖОРЛОН

Ерөнхий шаардлага


Бага насны хүүхэд, өндөр настнуудад зориулсан нэмэлт тоноглол хийж болно.

Эрүүл ахуйн шаардлага

Агаарын урсгал чөлөөтэй явагдах нөхцлийг хангаж байрлуулна.

Байршил

Гэр, амины орон сууцны гадна байхаар төлөвлөнө.



Хажуугийн зүсэлттэй зураг

Урд талын зүсэлттэй зураг

Хэрэглээ үйлчилгээ

- Суурийн хоёр тасалгааг ээлжлэн хэрэглэнэ. Хэрэглэж байгаа суурийн тасалгаа ялгадсаар дүүрэх үед бие засах нүхийг таглаж, нөгөө тасалгааг хэрэглэнэ.
- Жорлонгийн шалыг усаар тогтмол угааж, цэвэрлэнэ.
- Өтгөн хураах саванд угаадас, хог хаягдал, халдваргүйжүүлэгч бодис хийхийг хориглоно.
- Агааржуулалтын хоолойг хар өнгөөр будах ба энэ нь ялгадас хатах явцыг дэмжинэ.

НҮХЭН ЖОРЛОНГИЙН ТӨРӨЛ-4

“ЖОРЛОН” ҮНДЭСНИЙ ЧУУЛГАНААС ГАРСАН ЗӨВЛӨМЖ

2022 оны 3 дугаар сарын 31-ний өдөр

Улаанбаатар хот

“Жорлон” үндэсний чуулганаар хөрсний бохирдлыг бууруулах, урьдчилан сэргийлэх, хөрс хамгаалах, гэр хороолол болон аялал жуулчлалын бүс, автозамын дагуух үйлчилгээний цогцолбор, нийтийн ариун цэврийн байгууламжийн тоог нэмэгдүүлэх, хууль, эрх зүйн орчныг шинэчлэх, хөрсний бохирдлыг бууруулах, урьдчилан сэргийлэх, байгальд ээлтэй, стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийн технологийн оновчтой шийдлийг түгээн дэлгэрүүлэх, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, цаашид авч хэрэгжүүлэх бодлого, арга хэмжээг тодорхойлох талаар дараах зөвлөмжийг гаргаж байна.

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хамтран ажиллах байгууллага
Нэг. Нэн тэргүүнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд		
1.	Хөрсний нянгийн болон хүнд металлын бохирдлын судалгааг нэмэгдүүлэх	ОББҮХ, ЭМЯ
2.	Туул, Сэлбэ гол дагуу усан сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүс, автозам дагуу, аялал жуулчлалын бүсэд байгаа нүхэн жорлонг буулгах;	НБОГ, УБХЗАА, УГ
3.	“Улаанбаатар хотын хөрсний чанарыг сайжруулах бүс тогтоож, дагаж мөрдөх журам”-ыг боловсруулж, хэрэгжүүлэх, татварын болон газрын тухай хууль тогтоомжтой уялдуулан хориглолт, хязгаарлалтыг тогтоох	БОАЖЯ, НЗДТГ, НЗАА
4.	Ногоон зээлийн хүүгийн зардалд олгох санхүүжилтийг нэмэгдүүлэх, гэрээ байгуулан зээл олгож байгаа банкнуудад аялал жуулчлалын бааз, автозамын дагуух үйлчилгээний цогцолборыг стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай болгох хүрээнд олгох зээлийг түргэн шуурхай шийдвэрлэх, тавигдах шаардлагыг уян хатан болгох	ОББҮХ
5.	Байгальд ээлтэй, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулж, иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэхээр ажиллаж байгаа иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжих	БОАЖЯ, ОББҮХ, БХБЯ, ЭМЯ
6.	Олон Улс, улсын чанартай авто замын дагуу холбогдох стандартад нийцсэн үйлчилгээний цогцолборыг өөрийн хөрөнгөөр, менежментийг хариуцах нөхцөлтэйгээр байгуулах төслийн ажлыг эрчимжүүлэх	ЗТХЯ, БОАЖЯ
7.	Нийтийн бие засах газрын тоо, хүртээмж, чанарыг нэмэгдүүлэх	НЗАА, НБОГ, 21 аймгийн ЗДТГ
8.	Нийслэлийн нутаг дэвсгэр дэх усан сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсэд оршиж байгаа айл өрхийн хөрс болон гүний усыг бохирдуулж байгаа стандартын шаардлага хангаагүй нүхэн жорлон, угаадасны нүхийг ашиглалтаас гаргаж, стандартын шаардлага хангасан эко жорлонгоор солих ажлыг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, иргэдийн оролцоотой үе шаттай шуурхай шийдвэрлэх	БОАЖЯ, БХБЯ, ОББҮХ, НЗДТГ, НЗАА, НБОГ, УСУГ, ТББ, холбоод
9.	Гэр хороолол болон аялал жуулчлалын бүсэд “Эко жорлон” арга хэмжээг хэрэгжүүлж, хөрсний бохирдлыг бууруулах ажлыг эрчимжүүлэх	БОАЖЯ, НЗАА, ОББҮХ, НБОГ
10.	Шатахуун түгээх станцуудыг ариун цэврийн байгууламжтай болгож, нийтэд үйлчлэх нээлттэй болгох	ЗТХЯ, 21 аймгийн БОАЖГ
11.	Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны 02, 03, 04 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг хангуулах, хяналт шалгалтыг эрчимжүүлэх	БОАЖЯ, 21 аймгийн БОАЖГ

12.	Нийслэлийн гэр хорооллыг хөгжүүлэх төслөөр хийгдэж буй инженерийн дэд бүтцэд гэр хорооллын айл өрхүүдийг холбох ажлыг зохион байгуулах	БХБЯ, УБХЗАА, НБОГ, ОББҮХ
Хоёр. Хууль эрхзүй, засаглалыг сайжруулах чиглэлээр		
13.	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах	БОАЖЯ
14.	Нийслэл Улаанбаатар хотын суурьшлын бүсэд иргэн, ИРГЭН, ААНБ-д газар эзэмших өмчлөх эрх шинээр олгохдоо бохирын шугамд холбогдсон эсэх эсвэл MNS 5924 : 2015 Нүхэн жорлон, угаадасны нүх. Техникийн шаардлага хангасан байх шаардлага тавих. (Хэрэв тус шаардлагыг хангаагүй тохиолдолд газар эзэмших эрх олгохоос татгалзах талаар хууль тогтоомжид зохицуулалт тусгах)	НЗД, БХБЯ, БОАЖЯ, УСУГ, УБХЗАА,
15.	Улаанбаатар хотын суурьшлын бүсэд нүхэн жорлон ашиглаж байгаа, орчныхоо хөрсийг органик болон органик бус бодис элемент, хатуу шингэн хог хаягдлаар бохирдуулж байгаа эсэхэд олон нийтийн хяналтыг нэмэгдүүлэх болон байгаль орчны болон эрүүл ахуйн хяналтын улсын байцаагчдын хяналт шалгалтыг эрчимжүүлэх	БОАЖЯ, НБОГ
Гурав. Аялал жуулчлалын бааз, автозамын дагуух үйлчилгээний цогцолборыг стандартын шаардлага хангуулсан ариун цэврийн байгууламжтай болгох хүрээнд		
16.	Аялал жуулчлалыг хөгжүүлэх, Монголд зочлох жилийн хүрээнд аялал жуулчлалын баазуудыг стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай болгох, нүхэн жорлонтой аялал жуулчлалын баазуудын үйл ажиллагааг хориглох;	БОАЖЯ, БХБЯ, УСУГ
17.	Аймаг, нийслэл болон аялал жуулчлалын гол бүс нутгийн сумдад стандартын шаардлага хангасан нийтийн ариун цэврийн байгууламжийн тоог нэмэгдүүлэх;	21 аймаг ЗДТГ, БОАЖГ
18.	Нийслэл, орон нутагт бохир соруулдаг машины тоог нэмэгдүүлэх	УСУГ
19.	Сайжруулсан ариун цэврийн байгууламжаас гарах бохирыг усанд урьдчилан цэвэрлэгээ хийж, ариутгах татуургын төвлөрсөн системд нийлүүлэх дэвшилтэт технологи бүхий юүлэх станц байгуулах	БХБЯ, УГ, УСУГ
20.	Жуулчид, үйлчлүүлэгчид, тээврийн жолоочид GPS-н мэдээллийн сан, google map-аас өөрт хамгийн ойр байх үйлчилгээний (ШТС, дугуй засвар, эмнэлгийн яаралтай тусламж г.м) талаарх мэдээллийг авах боломжийг бүрдүүлэх	ЗТХЯ, БОАЖЯ
Дөрөв. Салбарын хүний нөөцийг нэмэгдүүлэх, ажиллах нөхцлийг бүрдүүлэх хүрээнд		
21.	Салбарын судалгаа, шинжилгээний чадавхыг сайжруулах, материаллаг баазыг нэмэгдүүлэх, лабораторийг олон улсын түвшинд судалгаа шинжилгээ хийх боломжийг бүрдүүлэх, арга аргачлал, хөтөлбөрийг шинэчлэх.	ЦУОШГ, НЭМХ
Тав. Олон нийтийн хамтын ажиллагааг сайжруулах, сургалт сурталчилгааны хүрээнд		
22.	Олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, харъяа дүүрэг, хороо, орон нутагт идэвхжүүлэх ажлыг тогтмол зохион байгуулах	БОАЖ, НБОГ, 21 аймгийн БОАЖГ,
23.	Сайн жишиг, үлгэр жишээ айл өрхүүдийн талаар нэвтрүүлэг хийж олон нийтэд түгээх	ОББҮХ, НБОГ
24.	Иргэдийн ухамсарт нөлөөлөх видео, контентийг бэлтгэж олон нийтийн цахим сувгаар идэвхитэй сурталчлах	БОАЖЯ, ОББҮХ, АНЗДТГ



**ХОГОО АНГИЛЖ ХАЯХ НЬ БАЙГАЛЬ ДЭЛХИЙДЭЭ
ТУСАЛЖ БУЙ ЭХНИЙ АЛХАМ. ХАРИН АНГИЛЖ ХАЯХЫН
ТУЛД ХОГИЙН САВАА ЗӨВ БЭЛДЭХ НЬ ЧУХАЛ.**

ДАХИН БОЛОВСРУУЛАХ БОЛОМЖТОЙ “ДАХИВАР ХАЯГДАЛ”



Таны тарьсан хог байгальд хэдэн жилийн дараа шингэж алга болдог вэ.

		
Тамхины иш -2 жил	Бичгийн цаас 2 жил	Бэлэн хоолны сав устдаггүй
		
Хуучин гутал 10 жил	Аккумулятор 100 жил	Гялгар уут 200-1000 жил
		
Хаягдал зай 110 жил	Хувцар сав 400 жил	Шил 1000-4000 жил
		
Ундаа, пивоны лааз хөнгөн цагаан/ 500 жил	Дугуй 140 жил	Хэрэглэсэн живх 600 жил



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР



**ТА АСУУ
БИД ХАРИУЛЪЯ**



70543063, 99087636, 80059917,
80000233, 89648585, 88213512



Говьсүмбэр Байгаль орчин
www.baigal.gs.gov.mn

*Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын хүрээнд
мэдээлэл авах, асуух асуулт байвал*

**ТА МЭДЭХ
ЭРХТЭЙ.**

Мод



Аялал
жуулчлал



Байгаль орчны
үнээгээ



Ус



Хүрээлэн буй орчны
бохирдол /хог хаягдал/



Амьтан, урсгал,
биологийн олон янз байдал

